

## I. ҮНДСЭН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Компани 2019 онд 14 төсөвт байгууллага, 83 аж ахуйн нэгж, 1090 айл өрх, нийт 1187 хэрэглэгчтэй ус, дулааны эрчим хүчээр хангаж, бохир ус татан зайлуулах гэрээ байгуулан ажилласан.

### 1. Дулааны эрчим хүч

Тайлант онд 36.3 мян.Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэхээс 38.3 мян.Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэн 105.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Зуны улирал буюу 5.15-9.15 хүртэл 4 сар 1 зуух галлан орон сууцны хэрэглэгчдийг тасралтгүй хэрэгцээний халуун усаар ханган 593 тн нүүрс шатааж 1.2 мян.Гкал дулааны эрчим хүчийг үйлдвэрлэсэн.

Сүлжээний нэмэлт усны зарцуулалт төлөвлөгөөнөөс 5.3 мян.м<sup>3</sup>-ээр буурч 23.8мян.м<sup>3</sup> гарсан байна. Усны алдагдалтай холбоотой дуудлагыг хүлээн авч шуурхай барагдуулан, дулаан дамжуулах сүлжээ, түгээх сүлжээнд гарсан гэмтлийг шуурхай устгаж, түгээх шугамын шинэчлэлийн ажлыг үе шаттай хийж байгаа зэргээс шалтгаалан нэмэлт усны алдагдал багассан. Мөн Сумын хуучин тосгоны 2 давхар байрууд нь хэрэгцээний халуун усны шугамгүй учир хэрэглэгчид сүлжээний усыг зүй бусаар ашиглаж нэмэлт усны зарцуулалтыг ихэсгэдэг байдалд хяналт тавьж хэрэглэгчдээр эргэлт, ухуулга сурталчилгаа хийх, системд тавьсан крантыг авч заглушка тавих зэрэг ажил зохион байгуулан ажилласан.Сүлжээний нэмэлт усны цагийн зарцуулалт 3-5м<sup>3</sup>/ц болон буурсан. Технологийн давс 24.9 тонныг хэрэглэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 4.5 тонн буюу 18.0 хувиар буурсан байна.

### 2. Ус хангамж, ариутгал татуурга

415.8 мян.м<sup>3</sup> ус олборлохоос 383.5 мян.м<sup>3</sup> ус олборлон 92.2 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь төсвийн байгууллагууд, айл өрхийн усны тоолууржилтаас шалтгаалан зохистой хэрэглээ нэмэгдэж байгаа, мөн нүүрс угаах үйлдвэр ажиллахгүй байгаагаас ШГХК-ийн усны хэрэглээ буурсан зэргээс шалтгаалсан байна.

Одоогийн байдлаар төсвийн байгууллагын 100 хувь, бусад аж ахуй нэгж 97 хувь, айл өрхийн 81 хувь нь цэвэр усны тоолууржилтанд хамрагдсан байна.Энэ онд 30 айл өрх, 5аж ахуй нэгжид нийт 76 ширхэг тоолуур шинээр суурилуулсан.

315.6 мян.м<sup>3</sup> бохир ус татан зайлуулахаас гүйцэтгэлээр 337.3мян.м<sup>3</sup> бохир усыг татан зайлуулсан байна.

Үндсэн үйлдвэрлэлийн үзүүлэлтүүдийг мөн үетэй харьцуулан хүснэгтээр үзүүлбэл:

№	Нэр	Хэмжихнэгж	2018	2019		зөрүү	
			гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	өмнөх оноос	төлөвлөгөөнөөс
1	Үйлдвэрлэсэн ДЭХ	мян.Гкал	37.7	36.3	38.3	0.6	2
2	Дотоод хэрэглээ	мян.Гкал	3.2	3.2	3.2	0	0
3	Түгээсэн ДЭХ	мян.Гкал	34.5	33.1	35.1	0.6	2
4	Нүүрс	мян.тн	14.3	14.8	13.1	-1.2	-1.7
5	Нэмэлт ус	мян.тн	26.1	29.1	23.8	-2.3	-5.3
6	Давс	мян.тн	21.4	24.9	20.4	-1	-4.5
7	Цэвэр ус	мян.тн	422.1	415.8	383.5	-38.6	-32.3
8	ЦЭХ-ний хэрэглээ	мян.кВт.ц	2 266.4	2428.3	2 316.2	49.8	-112.1

Эрчим хүчний хэмнэлтийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажилласан бөгөөд тайлант онд 2 428.3 мян.кВт.ц ЦЭХ хэрэглэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 2 316.2 мян.кВт.ц хэрэглэн 112.1 мянган кВт.ц буюу 4.6 хувиар цахилгаан эрчим хүч хэмнэлт гарган ажилласан.

Сүлжээний усны насос, ус өргөх насосуудад давтамж хувьсгуур суурилуулснаар усны хэрэглээ, ачаалалд тохируулан ажиллагааны ашигтай горимыг тогтоон насосуудыг хувьсах горимоор ажиллуулах, эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмжөөр шинэчлэл хийж мөн 11,12 сард 32 хоног 1 зуух дутуу галласан зэргээс шалтгаалан ЦЭХ-ний хэрэглээг бууруулсан.

Хэрэглэгчдээс нийт 1170 дуудлага хүлээн авч шуурхай барагдуулан ажилласан. Ажил үйлчилгээний орлого 4,8 сая төгрөгийг төвлөрүүлэн ажилласан.

Дуудлагын тоо 2018 оноос 20 хувиар буурсан боловч байрны доорхи инженерийн шугам хоолой болон хэрэглэгчийн эзэмшлийн шугам, сантехникийн хэрэгслийн гэмтэлтэй холбоотой дуудлага мөн үеэс нэмэгдсэн. Хэрэглэгчдэд өөрсдийн эзэмшлийн шугам хоолой, сантехникийн хэрэгслийн ашиглалт засвар шинэчлэлийг хийх талаар зөвлөмж гарган хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Дуудлагыг төрлөөр нь ангилвал:


Дуудлагын төрөл	х.н	Халаалт	Хэрэгцээний халуун ус	Цэвэр ус	Бохир ус	Тоолуур	Бусад	Бүгд
2018 он	тоо	168	101	418	313	194	292	1486
2019 он	тоо	197	74	163	242	73	421	1170

## II. САНХҮҮ

Тайлант онд 2,693.1 сая төгрөгийн борлуулалт хийхээр төлөвлөн 2,639.4 сая төгрөгөөр борлуулалт хийж 98 хувийн гүйцэтгэлтэй байна. Эрчим хүчний алдагдлын татаас 454.5 сая төгрөгийн санхүүжилт авч, зардлыг 307.4 сая төгрөгөөр хэмнэн, алдагдал 324.9 сая төгрөг буюу 39 хувиар, борлуулалтын нэг төгрөгт ногдох зардлыг 0.07 нэгжээр тус тус бууруулан ажилласан байна.

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
Нийт зардал	3,726.2	3,418.8	(307.4)	92
Орлого: Үндсэн үйл ажиллагаа	2,572.6	2,482.8	(89.8)	97
Үндсэн бус үйл ажиллагаа	120.5	156.6	36.1	130
Санхүүжилт	500.0	454.5	(45.5)	91
Алдагдал	(533.1)	(324.9)	208.2	61
БО-ын 1 төгрөгт ногдох зардал	1.45	1.38	(0.07)	95


Санхүүгийн үзүүлэлтийг графикаар харуулвал:



### – БОРЛУУЛАЛТ


Үндсэн үйл ажиллагаанаас 2,572.6 сая төгрөгийн борлуулалт хийх төлөвлөгөөтэй байснаас 2,482.8 сая төгрөгийн борлуулалт хийж борлуулалтын төлөвлөгөөг 96.5 хувиар биелүүлжээ.

Нийт борлуулалтанд эзлэх хувь:



Борлуулалтын төлөвлөгөөгөөр 198.2 сая төгрөгийн цэвэр ус борлуулахаас 162.7 сая төгрөг буюу 82.1 хувь, 155.9 сая төгрөгийн бохир ус татан зайлуулахаар төлөвлөснөөс 138.4 сая төгрөг буюу 88.7 хувь, 2,129.7 сая төгрөгийн дулааны эрчим хүчний борлуулалт хийхээс 2,098.1 сая төгрөг буюу 98.5 хувь, 88.7 сая төгрөгийн хэрэгцээний халуун усны борлуулалт төлөвлөснөөс 83.6 сая төгрөг буюу 94.2 хувь тус тус биелүүлжээ.

Борлуулалт дутуу хийгдсэн нь 9-р сард ШГХК, 5,9 сард 2 төсвийн байгууллага халаалт аваагүйгээс, төсвийн байгууллагуудын усны хэрэглээг задгайгаар төлөвлөсөн боловч 6-р сараас цэвэр усны тоолуур суурилуулснаар цэвэр усны борлуулалтын орлого 60 хувиар буурсан зэргээс шалтгаалсан.





## – ОРЛОГО

Нийт 2,482.8 сая төгрөгийн борлуулалтын орлого төвлөрүүлэхээс 2,461.0 сая төгрөгийн борлуулалтын орлого төвлөрүүлж 99.1 хувийн биелэлттэй байна.

**Орлогын бүтцийг авч үзвэл:**

сая.төг

№	бүтээгдэхүүн	борлуулалт	орлого	зөрүү	хувь
<b>Үндсэн үйл ажиллагааны орлого</b>					
1	Цэвэр ус	162.7	147.6	(15.1)	90.7
2	Бохир ус	138.4	134.1	(4.3)	96.9
3	Халаалт	2,098.1	2,099.9	1.8	100.1
4	Хэрэглээний халуун ус	83.6	79.4	(4.2)	95
	<b>Дүн</b>	<b>2,482.8</b>	<b>2,461.0</b>	<b>(21.8)</b>	<b>99.1</b>
<b>Үндсэн бус үйл ажиллагааны орлого</b>					
1	Усны суурь хураамж	31.6	34.2	2.6	108.2
2	Засвар, ажил үйлчилгээ	6.5	35.3	28.8	543.1
3	ТАА-н орлого	16.7	16.8	0.1	100.6
4	Дулааны үйлчилгээний орлого	12.2	12.7	0.5	104.1
5	Хандив тусламжийн орлого	53.5	39.1	-14.4	73.1
6	Материалын борлуулалт	0	14.0	14.0	100
7	Алданги	0	4.5	4.5	100
	<b>Дүн</b>	<b>120.5</b>	<b>156.6</b>	<b>36.1</b>	<b>130</b>

Үндсэн бус үйл ажиллагааны орлогод Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны 8 дугаар сарын 29 өдрийн 383 тогтоолоор хэрэгцээний халуун ус тасралтгүй найдвартай түгээж байгаа тул дулааны үйлчилгээний хураамжийг 9.15 өдрөөс тооцож эхлэснээр 12,7 сая төгрөгийн орлого шинээр нэмэгдсэн. Мөн үйлчилгээнийхээ төрбөрөө барагдуулахгүй байгаа хэрэглэгчдэд 4.5 сая төгрөгийн алданги ноогдуулж авсан. Засвар үйлчилгээний 35.3 сая төгрөгийн орлого орсноос 30.5 сая төгрөг нь ажил үйлчилгээний орлого, 4.8 сая төгрөг нь төлбөрт дуудлагаар орсон орлого байна.

## – ЗАРДАЛ

Тайлант онд нийт зардлыг 3726.2 сая төгрөгөөр төлөвлөн гүйцэтгэлээр 3418.8 сая төгрөгийн зардал гаргаж 307.4 сая төгрөгөөр буюу 8.2 хувиар хэмнэсэн байна. Нийт зардлын 37.9 хувиар цалин, нийгмийн даатгал, 12 хувийг цахилгаан, 15.5 хувийг нүүрс, 1.7 хувийг урсгал засвар, 12.3 хувийг үндсэн хөрөнгийн элэгдэл, 3.9 хувийг ТУЗ, удирдлагын зардал тус тус эзэлж байна.

**Зардлыг хэмнэсэн шалтгааны талаар**

Нийт хэмнэгдсэн зардлын 45.3 хувийг цалин нийгмийн даатгалын зардал, 16.5 хувийг нүүрс, 10.9 хувийг үндсэн хөрөнгийн элэгдэл, 6.6 хувь урсгал засвар сэлбэг материал, 5.7 хувийг цахилгаан эрчим хүчний зардлын тус тус эзэлж байна.

Цалингийн зардал: Нийт цалинг тайлант онд төлөвлөгөөнөөс 121.9 сая төгрөгөөр хэмнэсэн байна. Шагнал цалинг 40 хувиар төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр дунджаар 30.9 хувьтай байна. Шинээр 6 хүн ажилд орсноор шагнал цалин болон нэмэгдэл цалин хэмнэгдсэн мөн 3 ажилтны орон тоо дутуу байна.

№	Зардлын төрөл	2017 он	2018 он	2019 он		Зөрүү	Хувь
				төлөвлөгөө	гүйцэтгэл		
1	Цалин	991.3	1,151.3	1,252.2	1,130.2	-121,9	90,3
2	НДШимтгэл	128.4	161,7	181,6	164,4	-17,2	90,5
<b>Нийт цалин</b>		<b>1,119.7</b>	<b>1,313.0</b>	<b>1,433.8</b>	<b>1,294.6</b>	<b>-139,1</b>	<b>90,3</b>
<b>Сарын үр дүн</b>		<b>121,4</b>	<b>160,1</b>	<b>241,0</b>	<b>186,2</b>	<b>54,8</b>	<b>77,2</b>
<b>Жилийн үр дүн</b>		<b>23,9</b>	<b>123,9</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

Цахилгааны зардал: 112141 кВт.цбуюу 17,6 сая төгрөгийн цахилгааны хэмнэлт гаргасан. Тайлант онд техникийн шинэчлэл хийсэн мөн гадна агаарны температур дунджаар дулаан байснаас шалтгаалан 11,12-р сард 32 хоног 1 зуух дутуу галласан.

Урсгал засвар болон сэлбэг хангамжийн зардал: Төлөвлөгөөнөөс 20,2 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна. Зарим засварын ажлаас худалдан авалтын хэмнэлт гаргаж тэвчиж болох зардлыг тэвчин хэмнэлт гарган ажилласан.

Шатахуун: Шатахууны үнэ тайлант онд өмнөх оноос дунджаар 16,3 хувиар нэмэгдсэн ч зохион байгуулалтын арга хэмжээ авч хэмнэж ажилласан.

Нүүрсний зардал: 2019 онд дулаан үйлдвэрлэхэд 14,760 тн нүүрс шатааж 581,0 сая төгрөгийн түлшний зардал гаргахаас гүйцэтгэлээр 13,466 тн нүүрс шатааж 530,3 сая төгрөгийн түлшний зардал гаргаж ажиллаад байна. Түлшний зардлыг 1294тн-оор буюу 50,7 сая төгрөгөөр хэмнэсэн байна. Тайлант онд орчны температур харьцангуй дулаан мөн нүүрсний чанар сайн байсан нь нөлөөлсөн байна.

**Зардлын хэтрэлтийн талаар**

**Зээлийн хүүгийн зардал:** 2019 онд Land Cruiser prado 150 машины зээлийн хүү төлөхөөр 12.9 сая төгрөг төлөвлөн графикт төлөлтөөр 12,9 сая төгрөг төлсөн ба 2019 оны 07-р сарын 25-ны 23 тоот тогтоолын дагуу хэрэглээний шугамын зээлийн 11,6 сая төгрөгийн хүү төлсөн.

**Бусад зардал:** Туслах аж ахуйн зардал 7,8 сая төгрөгөөр төлөвлөн 6.3 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан. ТУЗ-ийн 2019 оны 11-р сарын 01-ний 31 тоот тогтоолын дагуу найдваргүй авлагыг 12.2 сая төгрөгөөр зардалд бүртгэсэн. Үүнд:

- Орон сууц 4.4 сая төгрөг
- ААН 7.8 сая төгрөг тус тус ноогдуулсан.

№	Зардлын төрөл	Өссөн дүн			сая.төг
		төлөв	гүйц		Зөрүү
1	Цалин	1,252.2	1,130.2	(122.0)	90.3
2	НДШимтгэл	181.6	164.4	(17.2)	90.5
	<b>ДҮН</b>	<b>1,433.8</b>	<b>1,294.6</b>	<b>(139.1)</b>	90.3
3	Урсгал засвар	68.6	58.7	(9.9)	85.5
4	Хангамжийн материал	19.3	15.6	(3.6)	81.1
5	Туслах материал	9.8	6.8	(3.0)	69.0
6	Цахилгаан эрчим хүч	429.3	411.8	(17.6)	95.9
7	Дотоод хэрэгцээ	160.4	160.4	(0.0)	100.0
8	Нүүрс	581.0	530.3	(50.7)	91.3
9	ТУЗ-ийн зардал	58.6	54.5	(4.1)	93.0
10	Холбоо	6.2	4.9	(1.3)	79.2
11	Бичиг хэрэг	6.1	5.1	(1.0)	83.7
12	Албан томилолт	14.8	14.7	(0.1)	99.1
13	ҮХ-н элэгдэл	430.2	421.8	(8.4)	98.1
14	Хөдөлмөр хамгаалал	53.7	39.1	(14.6)	72.8
15	Шатахуун түлш, тос	57.2	55.3	(1.9)	96.6
16	Дээж шинжилгээ	1.9	1.8	(0.1)	94.5
17	ҮХХ-н татвар	39.6	6.0	(33.6)	15.1
18	Газрын татвар	2.6	0.9	(1.7)	33.2
19	АТӨЯХ-н татвар	0.8	0.5	(0.3)	0.0
20	Усны нөөц ашиг. татвар	2.4	1.7	(0.7)	70.5
21	Бусдаар гүйц. ажил	77.8	77.0	(0.8)	99.0
22	Нийгэм САХэмжээ	85.3	73.9	(11.4)	86.6
23	Сургалт	17.4	14.2	(3.2)	81.5
24	Хэвлэл захиалга	0.5	0.4	(0.1)	89.8
25	Сэлбэг хэрэгсэл	15.0	12.3	(2.7)	81.9
26	Гүйцэтгэх удирдлагын зардал	90.7	79.8	(10.9)	88.0
27	Байгаль орчны нөлөөлөл	3.0	1.3	(1.7)	0.0
28	Усны зардал	39.3	32.3	(7.0)	82.3
29	Зээлийн хүүгийн зардал	13.0	24.5	11.5	188.9
30	Бусад зардал	7.8	18.5	10.7	237.3
	<b>НИЙТ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,726.2</b>	<b>3,418.8</b>	<b>(307.4)</b>	<b>91.8</b>

## – АВЛАГА

					<i>сая.төг</i>
№	Авлагын төрөл	2018.12.31	2019.12.31	Өсөлт бууралт (+-)	Тайлбар
1	Төсөв	2.7	0	-2.7	
2	ААНэгж	198.3	212.7	14.4	Аж ахуйн нэгж байгууллагуудтай тооцоо нийлж, төлөлтийн график мөрдөж ажилласан. ШГХК-н тооцоо орсон /184.7 сая/
3	Орон сууц	113.4	122.6	9.2	Байцаагч нар айл өрх бүртэй тооцоо хийж, төлөлтийн график мөрдөж ажилласан.
<b>Дүн</b>		<b>314.4</b>	<b>335.3</b>	<b>20.9</b>	
4	Хувь хүмүүс, ажилчдаас авах авлага		2.2	2.2	Хувь хүмүүс, ажилтнуудтай тооцоо хийж, төлөлтийн график мөрдөж ажилласан.
5	Бусад авлага	12.2	4.7	-7.4	Трансвель-4,7 сая
<b>дүн</b>		<b>12.2</b>	<b>6.9</b>	<b>-5.2</b>	
<b>НИЙТ ДҮН</b>		<b>326.6</b>	<b>342.3</b>	<b>15.7</b>	

**Тайлант онд:**

- Орон сууцны хэрэглэгчдийн авлага 9.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь 9 дүгээр сарын 15-наас дулааны үйлчилгээний хураамж авдаг болсноор төлбөр дундажаар 17.4 хувиар нэмэгдсэн, оны эцэст хэрэглэгчдийн борлуулалтанд хийсэн дотоод хяналтын хийсэн шалгалтаар 3,6 сая төгрөгийн нөхөн бичилт хийсэн зэргээс шалтгаалсан байна.
- Тайлант онд ШГХК-аас 184,7 сая төгрөгийн авлагатай байна. ШГХК-ний 178,0 сая төгрөгийн авлагыг авахаар 2018 оны эцэст хуулийн байгууллагат хамтран ажиллаж манай талд шийдвэрлэгдсэн боловч хариуцагч тал зөвшөөрөхгүйн улмаас маргаантай байгаа нь авлагын бууралтанд нөлөөлсөн. Уг авлагыг тайлант ондоо багтаан шийдвэрлэхээр төлөвлөсөн боловч шүүх хурал удаа дараа хойшлогдсноор он дотроо багтаан шийдвэрлэж чадаагүй.
- Харилцагч бусад байгууллага болон хувь хүмүүс, ажилтнуудаас авах авлагын тооцоог ажил үйлчилгээ, гүйлгээ гарсан тухай бүр санхүүгийн тайланд тусган, тооцоо нийлж, дараа тайлангийн гүйцэтгэлийг хугацаанд нь гаргуулан ажилласан.

- Цаашид авлага барагдуулах ажлыг эрчимжүүлж, харилцагчидтай тооцоо нийлэн тодорхой хугацаанд төлбөрөө төлөх гэрээ байгуулан, хугацаа хожимдсон тохиолдолд алданги тооцох, барагдуулаагүй бол таслалт хийх зэргээр харилцан тохиролцож албан мэдэгдэл хүргүүлэн мөн ШШГүйцэтгэгч болон гэрээт өмгөөлөгчтэйгээ хамтран ажиллаж байна. Ажлын үр дүнг борлуулалтын орлогын байцаагч нарын цалин урамшуулалтай уялдуулсан журмыг боловсруулан мөрдөн ажиллаж байна.

– ӨГЛӨГ

	Өглөг	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
Хуримтлагдсан	Татвар	284.8	411.6	126.8
	НДШ	118.5	175.1	56.6
	Цахилгаан	573.8	536.8	-37.0
	ДДЦС	209.2	209.2	0.0
	Дүн	1186.3	1332.7	146.4
	Бусад өглөг	156.6	123.1	-33.5
	Богино хугацаат зээл	0	138.4	138.4
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>1342.9</b>	<b>1594.2</b>	<b>251.3</b>

**Тайлант онд:**

Цахилгааны өр төлбөр 37.0 сая төгрөгөөр буурч, татварын өр төлбөр 126,8 сая төгрөгөөр, НДШ 56.6 сая төгрөгөөр өссөн байна.

2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах, үндсэн үйлдвэрлэлийн тасралтгүй үйл ажиллагааг хангахад зайлшгүй шаардагдах хөрөнгө оруулалт, их болон урсгал засвар, ТЗБАХ-ний хүрээнд хийгдэх ажлуудыг хийж гүйцэтгэх, ажиллагсдын цалин хөлсийг цаг хугацаанд нь санхүүжүүлэх зорилгоор авсан хэрэглээний шугамын зээл 138.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Цаашид өр төлбөрийн судалгаа гарган, мөнгөн хөрөнгийн урсгалыг оновчтой тооцоолон, графикт төлөлт хийн барагдуулахаар ажиллаж байна.

ШГХК-иас авах 178,0 сая төгрөгийн авлага нь шүүхээр шийдвэрлүүлэхээр маргаантай байгаа нь өр төлбөрийн бууралтанд нөлөөлж байна. / энэ авлага шийдвэрлэгдсэнээр татварын өр төлбөрт хаалтаар барагдуулахаар тохиролцсон /

– ХУДАЛДАН АВАЛТЫН ТАЛААР

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 02 дугаар тогтоолоор худалдан авалтын төлөвлөгөөг 230 гаруй нэр төрлийн бараа ажил үйлчилгээг худалдан авахаар 567,24 сая төгрөг батлуулсан. Эрчим хүчний сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн дугаар 275 тушаалаар 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулсан ба Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор компаний 2019 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулснаар 613,93 сая төгрөг болсон. Худалдан авалтын төлөвлөгөөг цаг тухай бүрт нь TENDER.GOV.MN сайтад дэлгэрэнгүй байршуулж худалдан авах ажиллагааны хууль, тогтоомжид нийцүүлэн ажилласан. 2019 оны гүйцэтгэлээр 450,44 сая төгрөгийн худалдан авалт хийж 73,4 хувь байна.

09 дүгээр сарын нэмэлт өөрчлөлтөөр Харьцуулалтын аргаар худалдан авах бараа ажил үйлчилгээнээс 10,3 сая төгрөгийн хэмнэлтийг, 23,0 сая төгрөгийн “Ус түгээх 2 худаг барих” ажлын төсвийг бусад төсөл арга хэмжээ рүү тодотгон өөрчилсөн.

Төлөвлөгөөнд тусгагдсан Нээлттэй тендер шалгаруулалт 1, харьцуулалтын аргаар худалдан авах 7 нийт 8 ажлыг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн дагуу зохион байгуулсан. Үүнээс “Түлш шатахуун, Тослох материал” худалдан авах 66,5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий нээлттэй тендер шалгаруулалтыг 2 удаа TENDER.GOV.MN сайтад урилгыг нийтлэн зарласан боловч оролцогч тендер ирүүлээгүй амжилтгүй болж “Халиун Шарын гол” ХХК-тай Шууд гэрээ байгуулсан.

Харьцуулалтын аргаар худалдан авах бараа, ажил үйлчилгээ болох “Дулааны станцын хэсгийн 220,218-н дээврийн засварын ажил ажил”, “Дулааны станцын гадна фасад хийх, цонх шинэчлэх ажил”, “Бохир усны станцыг бүрэн автоматжуулж алсын удирдлагад шилжүүлэх”, “Контторын барилгын өргөтгөл хийх / хэрэглэгчдэд үйлчлэх төв/” зэрэг 4 ажлыг цахимд урилгыг нийтлэснээр оролцогч үнийн санал ирүүлж гэрээ байгуулсан. “СЭН-1 -д Давтамж хувиргуур суурилуулах”, “Ажлын хувцас, гутал” зэрэг 2 ажлыг 2 удаа зарлан амжилтгүй болсон тул Дархан-Уул аймагт энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Жижиг дунд үйлдвэрлэгч Ромелт ХХК-тай “Ажлын хувцас, гутал” худалдан авах, Энлает ХХК-тай “СЭН-1-д Давтамж хувиргуур суурилуулах” шууд гэрээ тус тус байгуулсан. “Ус зөөврийн автомашин худалдан авах харьцуулалт 2 удаа амжилтгүй болсон ба Нью Сمارт хаус ХХК-тай

Шууд гэрээ байгуулсан боловч санал болгосон автомашин шаардлагад нийцээгүй учир гэрээг цуцалсан.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33.4 дэх заалтад үндэслэн амжилтгүй болсон тендерүүдийг 34 дүгээр зүйл 34.1 буюу Шууд гэрээ байгуулахдаа тус хуулийн 34.3 захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн.

227,1 сая төгрөгийн шууд худалдан авалт хийхээр төлөвлөснөөс гүйцэтгэл 163,5 сая төгрөг байна. 63,6төгрөгийн худалдан авалт нь хөрөнгө санхүүгийн дутагдлаас шалтгаалан хийгээгүй болно.

сая.төг							
№	Тендер шалгаруулалтын журам /арга/	Батлагдсан нийт төсөв	Гэрээний дүн	Хэмнэлт	Хийгдээгүй	Тендер шалгаруулалтын тоо	Цахим тендер шалгаруулалтын тоо
1	Нээлттэй тендер шалгаруулалтын журам	146,5	66,5		80,0	2	1
2	Харьцуулалтын арга	240,3	240,3		-	7	
3	Шууд худалдан авалт	227,1	163,5		63,6		
<b>ДҮН</b>		<b>613,9</b>	<b>470,3</b>		<b>143,6</b>	<b>9</b>	<b>1</b>

Худалдан авалтын төлөвлөгөө, Нээлттэй тендер шалгаруулалт, үнийн санал авах урилгыг TENDER.GOV.MN сайтад дэлгэрэнгүй байршуулан олон нийтэд мэдээлж, цахим болон уламжлалт аргаар зохион байгуулсан. Мөн Чанар стандартын шаардлага хангасан дотоодын Еден ХХК, Глобал ациттелон ХХК, Шарын гол ХК, Монгол базальт ХХК, Ромелт ХХК, Витафит ХХК зэрэг үйдвэрлэгчдээс худалдан авалт хийсэн.

Тендер шалгаруулалтын үнэлгээг тендерийн хүчинтэй байх хугацаанд хийж гүйцэтгэн худалдан авах ажиллагааны хуулийн дагуу зохион байгуулж, худалдан авах ажиллагааны явцад ямар нэг зөрчил, худалдан авах ажиллагааны талаар гомдол гараагүй.

### III. ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАРЫН ТАЛААР.

2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд 32 багц ажил хийхээр төлөвлөн хэрэгжилтийг 100 хувь ханган ажиллалаа. Үүнд:

- ✓ Зохион байгуулалтын талаар 7 багц ажил төлөвлөж 100 хувь хийж гүйцэтгэсэн
- ✓ Техник тоног, төхөөрөмж ашиглалт засварын талаар 21 багц ажил төлөвлөсөн, гүйцэтгэл 100 хувьтай ажлууд бүрэн хийгдэж дууссан.
- ✓ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, сургалтын талаар 4 багц ажил төлөвлөж 100 хувь хийж гүйцэтгэсэн байна.

#### ИХ ЗАСВАР, ТЗБАХ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ.

Компанийн ТУЗ-ийн 2019.01.08-ны өдрийн 09 тоот тогтоолоор 2019 оны их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтаар 321.8 сая төгрөгийн 17 багц ажил хийгдэхээр төлөвлөгөөг батлуулсан.

Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт хийх санал оруулж, Эрчим хүчний сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 275 дугаар тушаалаар 17 багц ажлыг 368.5 сая төгрөгөөр хийхээр шийдвэрлүүлсэн.

2019 онд

- Их засвараар 5 багц ажил төлөвлөн 100 хувь хийгдэж, 101.5 сая төгрөгийг,
- ТЗБАХ-ээр 5 багц ажил төлөвлөн 100 хувь хийгдэж, 125.2 сая төгрөгийг,
- Хөрөнгө оруулалтын 7 төрлийн машин тоног төхөөрөмж бараа материал авахаар төлөвлөж 5 ажил 100 хувь хийгдэж 31.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Төлөвлөгөөнд тусгасан ус зөөврийн автомашин, экскаватор худалдан авах ажлыг хөрөнгө санхүүгийн дутагдал болон БХБЯ-нд удаа дараа хүсэлт тавьснаар улсын төсөв, олон улсын төсөл хөтөлбөрт хамруулан шийдвэрлүүлэх боломжтой гэсэн хариу ирсэн тул хойшлуулсан.

Нийт Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтын ажилд 258.1 сая төгрөг зарцуулсан байна.

#### УРСГАЛ ЗАСВАР:

Зуух, туслах тоноглол, шугам сүлжээний урсгал засвараар 44 багц ажил хийхээр төлөвлөж, 58.2 сая төгрөгт зарцуулан 100 хувь хийж гүйцэтгэсэн.




## Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл


№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Шаардагдах хөрөнгө /мян.төг/		зарцуулсан хөрөнгө /мян.төг/	хөрөнгийн хувь	Гүйцэтгэл
				анх төлөвлөсөн	тодотгосон			
<b>1.Их засвар</b>								
1	"Дулааны станц"хэсгийн 220,218-н дээврийн засварын ажил хийх	багц	1	25,317.6	25,300	25,300	100%	100%
2	КТП№401 400кВа-н трансформатор	багц	1	5,000.0	5,000.0	4,000.0	80%	100%
3	Дулааны станцын гадна фасад хийх, цонх шинэчлэх, деаэраторын хана өрөх	багц	1	53,000.0	53,000.0	53,000.0	100%	100%
4	Автокраны моторт их засвар хийх	багц	1	9,000.0	7,255.1	7,255.1	81%	100%
5	Гадна тохижилтын ажил	багц	1	20,000.0	20,000.0	11,985.0	60%	100%
	<b>ДҮН</b>			<b>112,317.6</b>	<b>110,555.1</b>	<b>101,540.1</b>	<b>90%</b>	<b>100%</b>
<b>2. ТЗБАХ</b>								
1	5-н давхар байрын халуун ус, хүйтэн усны тоолуур төвлөрүүлэлт	багц	1	6,835.0	6,195.1	6,094.2	89%	100%
2	Бохир усны станцыг бүрэн автоматжуулж алсын удирдлагад шилжүүлэх	багц	1	50,000.0	44,627.0	44,627.0	89%	100%
3	Конторын барилгын өргөтгөл хийх (хэрэглэгчдэд үйлчлэх төв)	багц	1	50,000.0	49,998.0	49,998.8	100%	100%
4	СЭН 1-д Давтамж хувьсгуур суурилуулах	багц	1	23,000.0	23,000.0	22,968.0	100%	100%
5	ЯЧ №9-н 6 кВ-т оруулгын кабель шугаманд тосон таслууруу суурилуулах	багц	1	2,650.0	2,650.0	1,520.0	57%	100%
	<b>ДҮН</b>			<b>132,485.0</b>	<b>126,470.1</b>	<b>125,208.0</b>	<b>95%</b>	<b>100%</b>
<b>3. Хөрөнгө оруулалтаар</b>								
1	Гүний усны насос	ш	1	9,500.0	9,500.0	5,073.0	53%	100%
2	Редуктор	ком	1	5,000.0	5,000.0	9,424.0		100%
3	Компьютер	багц	1	3,600.0	3,600.0	3,500.0	97%	100%
4	Принтер	багц	1	5,900.0	5,890.2	5,890.2	100%	100%
5	Ширээ, сандал, шкаф	багц	1	10,000.0	7,474.2	7,500.0	75%	100%
6	Ус зөөврийн машин худалдаж авах	ш	1	20,000.0	20,000.0	-	0%	0%
7	Экскаватор	багц	1	80,000.0	80,000.0	-	0%	0%
	<b>ДҮН</b>			<b>134,000.0</b>	<b>131,464.4</b>	<b>31,387.2</b>	<b>23%</b>	<b>71%</b>
	<b>НИЙТ ДҮН</b>			<b>378,802.6</b>	<b>368,489.6</b>	<b>258,135.3</b>	<b>68%</b>	<b>90%</b>

ТЕХНИК ДЭВШИЛ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

1. Бохир усны насос станцыг бүрэн автоматжуулж, алсын удирдлагад шилжүүлсэн.



2. Сүлжээний усны насосанд давтамж хувиргуур шинээр суурилуулсан.



3. Эрчим хүчний аудитын зөвлөмжийн дагуу 1 трансформаторын хүчин чадлыг бууруулж, эрчим хүчний хэмнэлттэй трансформатораар шинэчилсэн.



4. 5-н давхар байрны хэрэгцээний халуун хүйтэн усны босоо шугам шинэчлэн, усны тоолуур төвлөрүүлэлтийн ажлыг нэг орон сууцанд хийж гүйцэтгэсэн.





5. Компанийн төв байрыг өргөтгөн “Хэрэглэгчдэд үйлчлэх төв”-ийг шинээр байгуулсан.



Дээрх ажлуудыг хийж хэрэгжүүлснээр дараах үр өгөөж гарч байна Үүнд:

- Алсын зайн хяналт удирдлагын SCADA системийг нэвтрүүлж хэрэгжүүлснээр тоног төхөөрмжийн үйл ажиллагаандтавих хяналт, найдвартай ажиллагаа дээшилж, ажиллах хүчний зардал хэмнэх боломж бүрдсэн.
- Сүлжээний усны 1-р насосанд давтамж хувьсгуур суурилуулснаараачаалалд тохируулан хувьсах горимоор ажиллуулжцахилгаан эрчим хүчний хэмнэлтбий болсон.
- Конторын хүчин чадал өндөртэй 400 кВА хүчний трансформаторыг эрчим хүчний аудитын зөвлөмжийн дагуу ЭХ-ны хэмнэлттэй аморф зүрхэвчтэй 63 кВА-гийн хүчин чадалтай трансформатораар шинэчлснээр цахилгаан эрчим хүчний хэрэглээ, ашиглалтын зардал бууруулах боломж бүрдсэн.
- Тоолуур төвлөрүүлэлт хийгдсэнээр усны зөв хэрэглээг хангах, хэрэглэгчийн босоо шугамын гэмтэл, ХХУ халахгүй айлын холигчоор холилдох байдал бүрэн зогсож, өр үүсгэхгүй байх, төлбөрөө төлөөгүй Айл өрхийг бусад хэрэглэгчдэд хамааралгүй таслалт хийх нөхцөл бүрдэж орлого

- төвлөрүүлэлт сайжирсан. /2018 онд төвлөрүүлэлт хийгдсэн 14-р байрны авлага 1 590.0 мян.төг буюу 55% буурсан, 2019 онд хийгдсэн 8-р байрны 1-р узелийн хэрэглэгчийн авлага сүүлийн 2 сард 816.0 мян.төг буюу 13% буурсан байна./ Хэрэглээний халуун хүйтэн усны тоолуурын заалтыг хэрэглэгчээс үл хамааран нэг дороос авч байцаагчийн ажлыг хөнгөвчилсөн.
- Хэрэглэгчдэд үйлчлэх төвийг нээснээр диспетчерийн шуурхай удирдлага, сантехникийн дуудлага, ус дулааны төлбөрөө төлөх үйлчилгээг нэг цэгээс түргэн шуурхайг ая тухтай орчинд үзүүлэх боломж бүрдсэн.

#### **IV. ХАБЭА, АЖЛЫН БАЙРНЫ НӨХЦӨЛ САЙЖРУУЛАХ АЖЛЫН ТАЛААР :**

2019 онд компанийн нийт зардлын 1.1 хувь болох 39,1 сая төгрөгийг ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардалд зарцуулан ажилласан.

- Гэмтэл саатал, ослоос урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулан ажилласнаар технологийн зөрчилгүй ажилласан байна.
- Компанийн ажилчдын дунд аюулыг мэдээллэх хуудсыг ашиглан мэдээлэл өгч ажиллах журмыг шинэчлэн гаргаж батлуулан аюулыг мэдээллэх хуудсыг хэрэгжүүлэн нийт 11 аюулыг мэдээллэж, тухай бүр зөрчлийг устгах арга хэмжээг авч ажилласан.
- Нийт ажилчдыг “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв”-тэй гэрээ байгуулан ажиллагсдын ажлын байрны нөхцлөөс шалтгаалан ялгаатай үзлэг шинжилгээнд хамруулсан.
- Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хуулийн 18.1.2 дахь заалтын дагуу нийт ажилтнуудыг Практикал даатгалтай гэрээ байгуулан даатгалд хамруулсан.
- Аваари ослоос урьдчилан сэргийлж ажлын байрны I, II шатны үзлэгийг тогтмол хийж, III шатны үзлэгийг улирал бүр удирдлага болон ҮЭХ, ХАБЭА-н зөвлөлтэй хамтран зохион байгуулж илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажилласан. III Үзлэгээр нийт 68 зөрчил илрүүлэн устгуулах арга хэмжээг авч ажилласан.
- Дулааны станцын дээврийн засварын ажлыг хэсэгчлэн шинэчилж дээврээс ус гоожилтыг бүрэн зогсоосон.



- Ажилтнуудын биеийн алжаал оюуны ядаргааг тайлах, эв нэгдэл нөхөрлөлийг бэхжүүлэн, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх зорилгоор "ХӨДӨЛГӨӨН - ЭРҮҮЛ МЭНД СПОРТ" явган аялалаар Дархан хайрхан уулыг нар зөв бүтэн тойрч аялан,буухиа тэмцээн зохион байгуулсан.



- Ажлын байран дахь дасгал хөдөлгөөнийг тогтмол хийж хэвшүүлсэн.





- АЖЛЫН БАЙРНЫ НӨХЦЛИЙГ САЙЖРУУЛАХ, ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР:

Ажилчин албан хаагчдыг албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, хөдөлмөр хамгааллын хэрэгслээр бүрэн хангаж ажиллаж байна. Тайлант онд үйлдвэрийн бага эмчтэй болж ажилтан бүрийг ажилд гарахаас нь өмнө эмчийн үзлэгт оруулж, хор саармагжуулах бүтээгдэхүүнээр үйлчилж, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ, зөвлөгөөг цаг алдалгүй хүргэж ажиллалаа. Ингэж ажилласаны дүнд ажиллагсадын дундах өвчлөлийн хэмжээ өмнөх оныхоос тодорхой хэмжээгээр буурсан байна. Эрүүл мэндийн сайдын 2014 оны 34 дүгээр тушаалыг үндэслэн ажилтнуудыг эрүүл мэндийн хугацаат үзлэгт хамрууллаа. Эмчийн үзлэгийг зохион байгуулахдаа ажилтнуудын ажлын байрны онцлогыг харгалзан зохих эмчийн үзлэг шинжилгээг хийсэн болно. Эрүүл мэндийн үзлэгээр илэрсэн ажилтнуудын өвчлөлийг бууруулах, эмчилгээ хийлгэх, ажлын байрны нөхцлийг солих чиглэлд онцгой анхаарч байна.

#### Ү. КОМПАНИЙН ДОТООД ХЯНАЛТЫН ТАЛААР

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу 2014 онд гүйцэтгэх захирлын А/110 дугаар тушаалаар дотоод хяналтын нэгжийг байгуулан ажиллаж байна. Дотоод хяналтын нэгжийн компанийн үйлдвэрлэлийн, захиргаа, хүний нөөцийн удирдлага, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, санхүү бүртгэл, борлуулалтын үйл ажиллагааны чиглэлээр төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын зохион байгуулдаг.

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хийгдсэн дотоод хяналт шалгалтын хүрээнд 26 зөрчил илэрснийг тухай бүр арилгах, засаж залруулах арга хэмжээ авч ажилласан




Захиргаа, хүний нөөц, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн үйл ажиллагаанд хийгдсэн дотоод хяналт шалгалтын хүрээнд 21 зөрчил дутагдал илэрснийг хугацаатай зөвлөмж өгч арилгуулсан.



Санхүү бүртгэл, борлуулалтын үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтын хүрээнд 3.6 сая төгрөгийн үнийн дүн бүхий 31 зөрчилтэй асуудлыг залруулсан.

Хууль тогтоомжийн хэрэгжилт, техник ашиглалт, засварын чанар, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлэх, эрсдлийг үнэлэх зорилгоор Эрчим хүчний сайдын 2020 оны 85 дугаар тушаалын дагуу “Эрчим хүчний хөгжлийн төв”-тэй дотоод хяналт шалгалт хийх гэрээ байгуулснаар үр дүнтэй дотоод хяналт шалгалтын тогтолцоог бүрдүүлэх боломж бүрдлээ.



## ҮІ.ХҮНИЙ НӨӨЦ, СУРГАЛТЫН ТАЛААР

### – АЖИЛЛАГСДЫН НИЙГМИЙН АСУУДАЛ

Тус компани тайлант онд 115 ажилтны орон тоо батлагдсан боловч, зарим ажлыг хавсран гүйцэтгэх, сэлгэн ажиллуулах зэргээр орон тоо хэмнэж нийт 112 ажилтан ажиллуулсан. Нэг өрх дунджаар 4 ам бүлтэй гэж үзвэл Шарын гол сумын 500 гаруй иргэний амьдрал ахуй тус компаниас хамаарч байгаа юм.

– Ажиллагсдын цалин хөлс, шагнал урамшууллын талаар : Ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд 2019 онд ажилтан бүрийн үндсэн цалин 50,000 төгрөгөөр нэмэгдүүлсэн. Үндсэн цалинг нэмэгдүүлснээр цалин хөлсний бусад бүрэлдэхүүн хэсэг болох нэмэгдэл хөлс, шагнал урамшууллын хэмжээ нэмэгдэж, ажиллагсдын бодит орлого дунджаар 8,7 хувиар өсжээ.. Ажиллагсдын шагналт цалинг хэмжээг 40 хүртлэх хувиар бодож олгохоор төлөвлөж, жилийн дунджаар гүйцэтгэл 30,9 байна. Сар бүр ажиллагсдад хоолны мөнгийг өдрийн 2000 төгрөгөөр , алслагдсан объект болох Буянтын худаг дээр ажилладаг ажилчдын унааны зардлыг нэг гараанд 5000 төгрөгөөр тооцон тус тус олгож байна. Ажилчин албан хаагчдын ажилласан жилийг харгалзан тогтвор сууршилын нэмэгдлийг 5-35 хувиар бодон олгосон.

– Хамтын гэрээний биелэлтийн талаар: Компанийн зүгээс хамтын гэрээнд нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар хүлээсэн үүргээ цаг тухайд биелүүлж ирлээ. Үүнд:

- Компанийн ажилтан бүрд 50,000 төгрөгийн халаалтын улирлын хөнгөлөлтөнд 5 сая төгрөг зарцуулж, ая тухтай өвөлжих боломжийг бүрдүүлсэн.
- Тайлант онд амаржсан 3 ажилтан тус бүрд нь 1 шөлний хонь, эхнэр нь амаржсан 2 ажилтанд аавын цалинтай 5 хоногийн чөлөө олгосон.



- Ойр дотны хүнээ алдсан ажилтан 4 ажилтанд тус бүр 400,000 төгрөгийн тусламж үзүүлэн уй гашууг нь хуваалцсан.
- “Үйлдвэрийн осол, хурц хордлогод өртөгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр”-ийг тохиолдуулан үйлдвэрлэлийн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан 2 ажилтанд тус бүр 100,000 төгрөгийн тусламж үзүүлсэн.
- Эх үрсийн баярыг тохиолдуулан ажиллагсдын хүүхдүүдийн дунд тэмцээн уралдаан зохион байгуулж, компанийн үйл ажиллагаатай танилцуулан 136 хүүхдэд бэлэг дурсгал гардуулж, 1,4 сая төгрөг зарцуулсан. Мөн шинэ жилийн баяраар “онц” сурсан ажилчдын 13 хүүхдэд компанийн бэлэг гардууллаа.
- Компаниас өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ахмадуудыг Сар шинийн баяр, Эрчим хүчний баяраар хүлээн авч, хүндэтгэл үзүүлдэг. Мөн Ахмадын баярын өдрийг тохиолдуулан ахмад бүрд 100,000 төгрөгийн дэмжлэг үзүүлдэг.

– Шагнал урамшууллын талаар: Хамт олноо ажил үйлсээрээ хошуучилан олон жил үр бүтээлтэй ажилласан ажилтнуудыг Төрийн дээд шагнал “Алтан гадас” одонгоор 2, “Хөдөлмөрийн хүндэт медаль” –аар 1, Монгол улсын Засгийн газрын шагнал “Эрчим хүчний тэргүүний ажилтан” тэмдэгээр 1, Сангийн яамны “Жуух бичиг”-ээр 1, Дархан Уул аймгийн шагналаар 5, Сумын “Хүндэт тэмдэг”-ээр 2 ажилтан тус тус шагнасан.

Мөн сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үйлсэд оруулсан хувь нэмэр идэвхи зүтгэл үр бүтээлийг үнэлж манай хамт олныг “СУМЫН ХҮНДЭТ ТЭМДЭГ” – ээр шагнасан.

– Нийтийг хамарсан ажлын талаар: Ажиллагсдын дунд нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор фитнесийн өрөөг өөрсдийн дотоод нөөц бололцоог ашиглан засч тохижуулан спортоор хичээллэх боломжийг бий болгосон. Мөн сумын спортын ордонтой гэрээ байгуулан долоо хоногт нэг удаа нийт ажиллагсдыг нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх нөхцлийг хангаж өгсөн.

- Хэсэг нэгжийн хооронд уламжлал болон явагддаг “Шилжин явах цом” булаалдах тэмцээнийг зохион байгуулж нийт ажиллагсад идэвхтэй оролцлоо
- Ажилчдын нийгмийн идэвхийг өрнүүлэх, ажиллагсдын дунд ажил хэрэгч, эвсэг хамт олны уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор нийт ажиллагсдыг 9 багт хуваарилан сар бүр арга хэмжээ зохион байгуулж оны эцэст шилдэг багуудаа

шалгаруулсан нь ажиллагсдын идэвх санаачлагыг өрнүүлж, урмыг сэргээсэн шинэлэг ажил болсон.

– Тусламжийн талаар: Дулааны станцын хэсгийн зуухны машинч Т.Альбекийн хүү А.Даулетжанд туслах хандивын аян өрнүүлж, эмчилгээний зардал 1,1 сая төгрөгийг хандивласан. А.Даулетжаны эмчилгээ амжилттай болж, эрүүл саруул болж, сурч хөгжих гэрэлт ирээдүйн зам нээгдсэн.

Компанийн туслах аж ахуйгаас зах зээлийн үнээс 30 хувь хямд үнээр ажилтнуудад хонь олгож, эрүүл аюулгүй мах хүнс хэрэглэх боломжийг бүрдүүлэн ажиллалаа.

#### – СУРГАЛТЫН ТАЛААР

2019 онд мэргэжлийн байгууллагуудын болон дотоодод зохион байгуулах ажилтны чадавхижуулах сургалтанд 14,2 сая төгрөгийг зарцуулсан.

Ажилчдыг чадавхижуулах, мэдлэг олгох, мэдлэгийг бататгах, мэргэжил ахиулах, мэргэшил олгох, гадаадын орнуудыг техник технологитой танилцаж туршлага судлах мэргэжлийн байгууллагуудын сургалт зөвөлгөөнд нийт 68 ажилтанг хамрууллаа. Шинээр ажилд орсон 7 ажилтан, өөр ажлын байранд шилжсэн ажилтны сургалтанд 4 ажилтан, ААД-ийн ээлжит шалгалтанд давхардсан тоогоор 105 ажилтан, ТАД-ийн шалгалтанд давхардсан тоогоор 69 ажилтан хамрагдсан. Компанид мөрдөгдөж байгаа хууль дүрэм журмын сургалт 2 удаа зохион байгуулагдаж нийт дахвардсан тоогоор 127 ажилтан хамрагдаж 88 ажилтан шалгалт өгч тэнцсэн байна. Байгууллагын хэмжээнд ажилчдыг чадавхижуулах, мэдлэгийг бататгах төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус сургалтыг 7 удаа зохион байгуулсан.

#### ГАДААД ДОТООД СУРГАЛТ




OZWater гадаад сургалт





ОХУ-ын Эрхүү хотноо зохион байгуулагдсан сургалт



Ухаалаг эрчим хүч -2019 ЭХЯ-ны сургалт



Enlighth ЖК-ийн зохион байгуулсан зураг



ААД, ТАД-ын шалгалт авч байгаа нь



Хүний нөөцийн программын сургалтын үеэр



Эрсдийн менежментийн сургалт



ГАУСтактикийн сургалт

## – КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД

Эрчим хүчний тухай хууль, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль болон бусад хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхээс гадна нийгмийн хариуцлагын хүрээнд сум орон нутгаас зохион байгуулсан ажлуудад идэвхтэй оролцож ирлээ. Тухайлбал

- Сумын малыг вакцинжуулах, урьдчилан сэргийлэх тарилга хийх компанит ажилд 4 ажилтан оролцсон
- Сумын цагдаагийн хэлтсээс зохион байгуулсан “олон нийтийн эргүүл”-д хуваарийн дагуу нийт 20 ажилтан эргүүлд гарч үүргээ сайн биелүүлсэн.
- Голын голидрол болон нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээг хуваарийн дагуу цэвэрлэсэн
- Жил бүр зохион байгуулагддаг “Усны өдөр”-ийг угтан хэрэглэгчдэд гарын авлага тарааж, орон нутгийн телевизээр “Усны зохистой хэрэглээ”-ний талаар сурталчилгаа явуулж ажиллалаа.
- Эрчим хүчний яамны болон Шарын гол сумаас зохион байгуулсан нээлттэй хаалганы өдөрлөгөөр компанийн үйл ажиллагааг сурталчлан ажилласан.
- Нийтийн аж ахуйн салбарын спорт, ажил мэргэжлийн уралдаанболон Шарын гол сумаас зохион байгуулсан “НИЙТИЙН БҮЖИГ НИЙТЭЭРЭЭ СУРЦГААЯ” уриан дор зохион байгуулсан тэмцээн уралдаанд амжилттай оролцсон.



Иргэдийн ая тухтай ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор дараах ажлуудыг тусгай зөвшөөрлийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

. Үүнд:

- Иргэдийг эрүүл ахуйн стандарт шаардлагыг хангасан цэвэр усаар хангах зорилгоор 7, 14 дүгээр байрны хүйтэн усны шугамыг шинэчилэн засварласан.

- Гэр хороолол дахь 6 дугаар сургууль, 2 дугаар цэцэрлэг, багийн байрыг төвлөрсөн ус хангамжийн системд бүрэн холбосон. Дээрх байгууллагууд эрүүл ахуйн стандартад нийцсэн цэвэр усаар найдвартай хангагдснаар хүүхдийн өвчлөл буурах, цэвэрлэгээ үйлчилгээ нь сайжрах, орчин нөхцөл нь дээшлэх зэрэг эерэг нөлөөг хүртэх юм. Мөн шинээр баригдсан багийн байрны гадна шугам, дотор сантехникийн угсралтыг хийж өгсөн. Ингэснээр иргэд багийн байрнаас төрийн үйлчилгээг хүртэх, багийн Засаг дарга, зохион байгуулагч нар аятай нөхцөлд ажиллах боломж бүрдсэн.
- Төсөвт байгууллагуудын ус, дулаан хангамжийг сайжруулах зорилгоор Соёлын төв, Эрүүл мэндийн төв, Спортын ордон, Цагдаагийн хэлтсийн шугам хоолойд засвар үйлчилгээг хийж гүйцэтгэсэн.
- Байгууллагын 50 жилийн ойн арга хэмжээний хүрээнд явган хүний зам барих, авто зогсоолын өргөтгөл, хашааны хаалга шинэчлэх зэрэг тохижилтын ажлуудыг хийсэн байна.